Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Дотоодын нийт бүтээгдэхүүн (Үйлдвэрлэлийн арга) хариуцсан мэргэжилтэн, Цэвээн Бадамцэцэг

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулна. | | | | | | | |
| 1 | Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана. | Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | УИХ-ын ээлжит сонгуультай холбогдуулан Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг 2024 оны сүүлийн хагаст батлах шаардлага үүссэн. Иймд Монгол Улсын 2025 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг дахин боловсруулан Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засгийн газрын хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барьсан. Хуулийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлж 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлуулаад байна. Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлтийн тооцооллыг хийж ажилласан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 2 | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг гүйцэтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө" батлуулсан. | - | Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай дотоодын нийт бүтээгдэхүүн болон уул уурхай, тээвэр, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025 оны төсөөллийг хийж, танилцуулгыг боловсруулсан ба Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засгийн газрын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуралдаанд танилцуулж, 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийг УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлж 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлуулаад байна. Хавсралт: 1 файл | | |
| 3 | Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2025 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна/ 1 танилцуулга/ | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай дотоодын нийт бүтээгдэхүүн болон уул уурхай, тээвэр, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025 оны төсөөллийг хийж, танилцуулгад тусгасан. 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг дахин УИХ-д өргөн барьж, нэгдсэн чуулганы | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуралдаанаар хэлэлцэж эхлээд байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.2. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлно. | | | | | | | |
| 4 | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулж, танилцуулна. | Дүн шинжилгээний тоо | Өмнөх онуудын эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн. | 2024 оны 2, 3 дугаар улирлын танилцуулга бэлтгэсэн байна. | Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж 2024 оны 1-3 дугаар улирлын (Macro diagnostics) дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулан яамны удирдлагууд болон олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан. Уг тайланд үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн болон болон уул уурхай, тээвэр, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбаруудын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, богино хугацааны төлөв байдлын талаар тайлбар бэлтгэн танилцуулгад тусгасан. Хавсралт: 3 файл | 2-р сар, 5-р сар, 8-р сар, 11-р сар | 100% |
| 5 | Макро эдийн засгийн богино, | Хөгжүүлсэн | Мэдээллийн | Загвар | GIZ байгууллагаас | 7-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана. | загварын тоо | дата баазыг бүрдүүлж, туршилт тооцооллуудыг гүйцэтгэсэн. | хөгжүүлсэн байна /1 загвар/ | зохион байгуулсан уур амьсгалын өөрчлөлтийн загвар хөгжүүлэх сургалтад хамрагдаж загварыг өөрийн орны онцлогт тохирсон загвар бий болгон эдийн засгийн тооцоо, төсөөлөлд ашиглаж байна. Мөн ОУВС-ийн Казакстан дах CCAMTAC төвөөс Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс 18-ны өдрийг хүртэл FPP загварыг хөгжүүлэх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. Макро эдийн засгийн дүн шинжилгээ, төсөөллийг уг FPP загвар болон MS Excel-д суурилсан tool ашиглан хийж, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн танилцуулгад тусгасан.<br>Хавсралт: 1 файл | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Макро эдийн засгийн 2024 оны 1-10 дугаар сарын танилцуулгыг тус бүр монгол, англи хэлээр цаг хугацаанд нь бэлтгэж, удирдлагуудад танилцуулж, газар, хэлтсийн дарга нарт хэвлэж түгээсэн. Уг сарын тайлангийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн салбарын танилцуулгыг бэлтгэж ажилласан.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 7 | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана. | Мэдээллийн тоо /Тоо/ | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/ | Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг шуурхай мэдээллээр power app аппликэйшний тусламжтайгаар тухай бүр хангаж байна.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 8 | Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт) | Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн. | Тайланд ашигласан тоо | Улирлын тайланд ашигласан байна. | Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macro diagnostics) тутмын танилцуулгад гаалийн дата, И-баримтын дата боловсруулан гадаад | 2-р сар, 5-р сар, 8-р сар, 11-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | худалдааны нөхцөл байдал, борлуулалтын нөхцөл байдалд шинжилгээ хийн тусгасан болно. | | |
| 9 | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг боловсруулна. | Судалгааны тоо | Судалгаанд шаардлагатай тоон мэдээллийг цуглуулсан. | Судалгаа боловсруулсан байна. /1 судалгаа/ | Эдийн засгийн урт хугацааны хандлагын судалгааг эдийн засгийн бодит секторын хувьд боловсруулсан. Уг тайланд үйлдвэрлэлийн аргаар тооцосн дотоодын нийт бүтээгдэхүүний шинжилгээг гүйцэтгэсэн. Хавсралт: 1 файл | 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 1.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлнэ. | | | | | | | |
| 10 | Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ. | Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан. | - | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүн болон уул уурхай, тээвэр, цахилгаан, худалдаа, үйлчилгээний салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025 оны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөөллийг хийж, танилцуулгад тусгасан. Мөн хуулийн төслийн тооцоололд шаардлагатай нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, бодит ДНБ-ий өсөлтийн хувь, төсвийн тусгай шаардлагад ашиглагдах уул уурхайн бус нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоолол, төсөөллийг хийж, хуулийн төсөлд тусгасан.<br>Хавсралт: 1 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Өөрийн хариуцсан чиг | Өөрийн хариуцсан чиг | Сургалт, семинар, | Сургалт, семинар, | ОУВС-ын Венийн Нэгдсэн Институтээс 2024.05.06-ны | 3-р сар, 6-р сар, 9-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | хэлэлцүүлэгт оролцсон. | хэлэлцүүлэгт оролцсон байх | өдрөөс 2024.05.17-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод зохион байгуулсан “Макро эдийн засгийн менежментийн асуудлууд” сургалтад оролцсон. Тус сургалтаар мөнгөний бодлогын шилжих механизм болон бизнесийн мөчлөгийн талаар судлах, макро эдийн засгийг тогтворжуулах мөнгөний болон төсвийн бодлогын үр нөлөөг судалж, макро эдийн засгийн суурь болон хувилбаруудын төсөөлөл хийх, төсөөлөл хийх арга зүйг сайжруулсан болно. Мөн яам, газар, хэлтсээс зохион байгуулагдсан холбогдох сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан. | сар, 12-р сар | |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан. | Мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх | "Ус усны нөөц ирээдүй", "Эрчим хүч хэмнэх энгийн боломжууд", "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд" зэрэг яамны мэдээллийн цаг, сургалтад хамрагдсан. | 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (Үйлдвэрлэлийн арга) хариуцсан мэргэжилтэн, Цэвээн Бадамцэцэг /............................................./
Огноо: ...2024.12.18......